

Урьдчилан цэвэрлэх байгууламжтай холбоотой чиг үүрэг
бүхий төрийн захиргааны байгууллагууд

Байгууллага	Алба, хэлтэс	Хаяг
Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба (УБЗАА)	Хотын инженерийн дэд бүтцийн газар	Хан-Уул дүүрэг, 23-р хороо, Наадамдын зам, Хангарди ордон Б блок
Барилгын хөгжлийн төв (БХТ)	Орон сууц нийтийн аж ахуйн хэлтэс	Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Баруун 4 зам, өөрийн байр
Усны газар (УГ)	Усны хяналт шинжилгээний хэлтэс	Баянгол дүүрэг, 2-р хороо, Чингүнжавын гудамж, Усны газрын байр
Хот, суурины ус хангамж, ариутгах татuurгын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хороо (ХСУХАТАУЗХ)	- Тусгай зөвшөөрөл хэрэглэгчийн газар - Үнэ тариф, судалгааны газар	Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Их тойруу 81/1, "Монгол Ньюс" тауэрын 6 давхар, 601 тоот.
Ус сүвгийн удирдах газар (УСУГ)	Бохирдол бууруулах нэгж	Баянзүрх дүүрэг, 3-р хороо, Токиогийн гудамж-5, Ус сүвгийн удирдах газар
Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам (БОУАӨЯ)	Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газар	Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, С.Данзангийн гудамж, Засгийн газрын II байр Г корпус.
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ)	Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар	- Дархан-Уул аймаг 45059, Дархан сум, 14 дүгээр баг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны байр - Улаанбаатар хот 13381, Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IX байр

ҮЙЛДВЭРИЙН ХАЯГДАЛ УСЫГ УРЬДЧИЛАН ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙГ ЗОХИСТОЙ СУУРИЛУУЛАХ НЬ

Үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд
зориулсан зааварчилгаа



Холбоо барих байгууллага: ХХААХҮЯ

- Дархан-Уул аймаг 45059, Дархан сум, 14 дүгээр баг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны байр
- Улаанбаатар хот 13381, Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IX байр

Цахим шуудан: mofa@mofa.gov.mn
Утасны дугаар: 51-262271

Анхааруулах нь: Энэ материалыг ЖАИКА-гийн "Улаанбаатар хотын үйлдвэрийн хаягдал усны хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл"-ийн ХХААХҮЯ-ны ахалж буй ажлын хэсгийн үйл ажиллагааны хүрээнд боловсруулсан. Хууль тогтоомжийн дэлгэрэнгүйг энд тусгах боломжгүй тул та өөрийн сонголтоор тус бичиг баримтыг ашиглана уу. Японы Засгийн газар болон Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАИКА) нь энэ бичиг баримтын агуулгад хариуцлага хүлээхгүй.



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



ХОТ БАЙГУУЛАЛТ,
БАРИЛГА,
ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ





ЗОРИЛГО




Энэхүү таниулах материалыг Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг, ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд хаягдал усаа нийлүүлдэг үйлдвэр, аж ахуйн нэгжүүд (ҮААН) –эд зориулан боловсрууллаа. Төвлөрсөн сүлжээнд үйлдвэрийн хаягдал ус нийлүүлэхэд 2024 оны 11 сард шинэчлэгдэн батлагдсан MNS6561:2024 “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага” стандартын шаардлагыг хангасан байх ёстой бөгөөд урьдчилан цэвэрлэх байгууламж (ҮЦБ) –тай, эсвэл шинээр байгуулах гэж байгаа ҮААН-ийн хувьд анхаарвал зохих голчухал зүйлсийг уг таниулах материалд багтаасан болно.

01

УЦБ-ИЙГ ТӨЛӨВЛӨХ НЬ

Үйлдвэр, аж ахуйн нэгжүүд УЦБ-аа төлөвлөж эхлэхдээ холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын тухай, мөн өөрийн үйлдвэрийн хэрэгцээ, шаардлагын талаар сайтар ойлгох нь чухал байдаг. Энэ хэсэгт MNS6561:2024 стандартын болон бусад холбогдох хууль, эрхзүйн шаардлагуудыг дурдсан бөгөөд эдгээрийг судалж мэдсэнээр зорилгоо тодорхойлох болон гэрээт ажил гүйцэтгэгчээ зөв сонгоход тань нэмэр болох юм.

Ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд хаягдал ус нийлүүлэх тохиолдолд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, MNS6561:2024 стандарт гэх мэт эрхзүйн бичиг баримтад дурдсан шаардлагуудыг хангах ёстой байдаг. Доорх зурагт таны биелүүлэх ёстой шаардлагуудыг нэгтгэн харууллаа.



Урьдчилан цэвэрлэх байгууламж байгуулахтай холбоотой хууль, дүрэм



Та дараах шаардлагуудыг биелүүлэх ёстой бөгөөд үйлдвэрийн онцлогоос хамааран өөр нэмэлт шаардлагууд ч тавигдаж болзошгүй тул дэлгэрэнгүй мэдээллийг холбогдох төрийн захиргааны байгууллагаас авна уу.

Суурилуулахаас өмнө:

- Нийслэлийн байгаль орчны газар (НБОГ) эсвэл Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам (БОУАӨЯ) -аар байгаль орчны ерөнхий үнэлгээ хийлгэх (шаардлагатай бол нарийвчилсан үнэлгээ хийлгэх)
(Аль байгууллагаар хийлгэх тухайд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн Хавсралтыг харна уу)
- Түүл голын сав газрын захиргаа (хоногт 50 м³-с их хаягдал ус зайлуулах бол) эсвэл Дүүргийн засаг дарга (хоногт 50 м³-с бага хаягдал ус зайлуулах бол) -аас хаягдал ус зайлуулах зөвшөөрөл авах
- Цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээг хангагч байгууллага (УСУГ, ОСНААУГ) -тай байгуулах, үйлчилгээний төлбөр төлөх
- e-Water системийг ашиглан ус бохирдуулсны төлбөр төлөх


Зураг төсөл боловсруулах болон суурилуулах:

- Зураг төсөл боловсруулахдаа мэргэжлийн байгууллагад хандах, зураг төслийг Барилгын хөгжлийн төв (БХТ) -өөр хянуулж, магадлал хийлгэх
- Хот байгуулалт, хотын стандартын газар (Нийслэлийн ЗД-ын хэрэгжүүлэгч агентлаг) -аас барилгын ажлыг эхлүүлэх/үргэлжлүүлэх зөвшөөрөл авах
- Хяналт шалгалтын газар (Нийслэлийн ЗД-ын хэрэгжүүлэгч агентлаг) -т барилга, байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлт гаргах, улсын комисс ажиллуулах

Ашиглах:

- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хороо (ХСУХАТАУЗХ) -оос байгууламжийг ашиглах тусгай зөвшөөрөл авах
- БОУАӨЯ-аас химийн бодис ашиглах тусгай зөвшөөрөл авах
- Лав зайлуулж, ачуулахдаа хог хаягдлын эрх бүхий тээвэрлэгчтэй гэрээ байгуулах
- Хаягдал ус соруулж, тээвэрлүүлэх бол эрх бүхий бохир ус тээвэрлэгчтэй гэрээ байгуулах

Дээрх шаардлагуудыг биелүүлэхээс гадна бохирдуулах бодисуудын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, санал болгож буй цэвэрлэгээний түвшин болон хянах, тайлагнахтай холбоотой шаардлагуудыг багтаасан MNS6561:2024 стандартыг хангасан хаягдал ус гаргах ҮЦБ байгуулах ёстой юм. Гол бохирдуулах бодисууд болох умбуур бодис, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч (БХХ), химийн хэрэгцээт хүчилтөрөгч (ХХХ)-ийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ нь үйлдвэрийн ангилал (сүү, сүүн бүтээгдэхүүн, мах, махан бүтээгдэхүүн гэх мэт) болон хоногт зайлуулах хаягдал усны хэмжээ (0-15м³, 15-240м³ болон 240м³-ээс их)-нээс хамаарах бөгөөд бусад үзүүлэлтүүд нь дээрх 2 нөхцлөөс хамаарахгүй.



Монголын Мянганы сорилтын сангийн боловсруулсан “Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх гарын авлага” нь танд өөрийн хэрэгцээг судалж мэдэх эхний алхам болох бөгөөд тус гарын авлагад үйлдвэрлэлийн салбараар ангилсан цэвэрлэгээний технологийн жишээ, хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны зардлын тооцоолол зэргийг тусгасан байдаг. Мөн дотоодын салбар нэгт үйлдвэрүүдийн туршлага, олон улсын туршлагаас суралцах нь ач холбогдолтой байдаг.

Гэрээлэгч нь УЦБ-ийг төлөвлөхөд танай үйлдвэрийн байршлын схем зураг, үйлдвэрлэлийн процесс, түүхий эд, усны хэрэглээ, хаягдал усны хэмжээ, шинж чанар гэх мэт маш олон төрлийн мэдээлэлд үндэслэдэг. Эдгээр мэдээллийг хурдан шуурхай гаргаж өгснөөр төлөвлөх, зураг төсөл боловсруулах хугацааг хэмнэнэ. Дараа нь гэрээлэгч үйлдвэрт очиж дээрх мэдээллийг магадлаж нягтлан, УЦБ-ийг төлөвлөх бөгөөд процессын урсгалын схем, шугам хоолойн болон тоног төхөөрөмжийн урсгалын схемийг боловсруулна.

Энэ үе шатанд гэрээлэгчтэй дор зүйлсийг хэлэлцэж ярилцах нь чухал бөгөөд MNS6561:2024 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээг авч үзэхээ битгий мартаарай.

- Хаягдал усны хэмжээ болон бохирдлыг бууруулах:** Зарим үйлдвэрлэлийн дамжлагаас гарах хаягдал ус нь бохирдол багатай бол үйлдвэрлэлийн бусад дамжлага буюу угаах, хөргөх гэх мэт ажиллагаанд дахин ашиглах. Ингэх нь хаягдал усны хэмжээг бууруулж, зардал болон зай талбайг хэмнэх боломжийг бүрдүүлнэ.
- Усны хэрэглээг багасгах замаар хаягдал усны хэмжээг бууруулах (жишээлбэл, ус хэмнэдэг цорго ашиглах гэх мэт)
- Хаягдал ус руу орж байгаа бохирдол/хаягдлыг багасгах (жишээ нь тоног төхөөрөмжийг угаахын өмнө наалдсан хог хаягдлыг хамж авах, шүүрдэж цэвэрлэх гэх мэт)
- Үйлдвэрлэлийн процессыг оновчтой болгох (жишээ нь үйлдвэрлэлийн үр бүтээмжийг дээшлүүлэх, бохирдол багатай түүхий эд ашиглах)
- Аюулгүй байдлыг хангах, гэнэтийн ослын үед авах арга хэмжээ:** Аюулгүй байдлыг хангах (жишээлбэл, аюулгүйн тэмдэг, дохио байрлуулах, хаягдал ус цэвэрлэх явцад хорт хий үүсэх магадлалтай тул хянах, хүчил/шүлт/тэсрэх/зэврэх бодисуудыг хүн хүрэхгүй газарт зөв хадгалах) ба гэнэтийн ослын үед авах арга хэмжээ (тоног төхөөрөмж эвдрэх, гал түймэр гарах, тэсэрч дэлбэрэх болон бусад)-ний талаар нухацтай авч үзэхийг гэрээлэгчээс шаардах
- Нөхцөл байдалд зохицуулах:** Үйлдвэрлэлийн процессоос шалтгаалан хаягдал усны хэмжээ/чанар хэлбэлздэг тул цэвэрлэгээний давтамж, химийн бодисын тун зэргийг тохируулах шаардлагатай. Харамсалтай нь үйлдвэрүүд энэ талаар мэдлэгтэй, мэргэжлийн хүний нөөцгүй байгаа нь хүндрэл үүсгэж байна. Иймээс гэрээлэгч УЦБ-ийг төлөвлөхдөө үүссэн нөхцөл байдалд зохицуулан тохируулах боломжтойгоор төлөвлөх нь зүйтэй (жишээлбэл, жигдрүүлэх сангийн хэмжээг зөв төлөвлөх, рН хяналтын төхөөрөмж болон химийн бодис автоматаар дозлогч суурилуулах). Мөн ажилтнуудыг дадлагажуулах сургалт зохион байгуулах, ашиглалтын дэлгэрэнгүй гарын авлага боловсруулах тухай бүү мартаарай.
- Хяналтын үзлэг болон бүртгэл:** Тоног төхөөрөмжийг зохистой ашиглах болон эвдрэл гэмтэл, үүссэн асуудлыг илрүүлж, шуурхай шийдвэрлэхийн тулд тогтмол хяналт, үзлэг хийж, бүртгэл хөтлөдөг байх шаардлагатай бөгөөд хаягдал усны хэмжээ, чанар, химийн бодисын тунгийн хэмжээ болон бусад үзүүлэлтийг уг бүртгэлд тусгана.

УЦБ-ийг байгуулахад Барилгын тухай хуулийн дагуу барилга байгууламжийг барихад шаардагдах процедурыг дагаж мөрдөнө. Үүнд БХТ-өөр зураг төслөө магадлуулах, барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл авах болон барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлт гарган улсын комисс ажиллуулах зэрэг багтана. Эдгээр процедурын тухай гэрээлэгчтэй ярилцаж шаардагдах бичиг баримтуудыг бүрдүүлж бэлдээрэй.

Монголд ихэнх үйлдвэр УЦБ байгуулахдаа хууль тогтоомжид заасан процедурыг дагаж мөрддөггүй, бичиг баримтыг зохистой бүрдүүлдэггүй тул тухайн байгууламж үйлдвэрт хир тохиромжтой, мөн MNS6561:2024 стандартын шаардлагыг хангахуйц төлөвлөгдсөн эсэхийг магадлахад хүндрэлтэй байна. Улмаар УЦБ шаардлага хангахгүй байх тохиолдолд хэн хариуцлага хүлээх нь тодорхойгүй байна. Тиймээс төлөвлөх үе шатанд бичиг баримтаа зохих ёсоор бүрдүүлэх нь зүйтэй бөгөөд заримыг нь гэрээлэгч бэлдэх ёстой.

03

АШИГЛАЛТ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ

Энэ хэсэгт ашиглалт, засвар үйлчилгээний үе шатанд анхаарвал зохих зүйлсийг дурдсан бөгөөд эдгээрийг мэдэж авснаар УЦБ-ийг цаашид үр дүнтэй ажиллуулахад дэмжлэг болох юм.

ХСХУХАТАҮЗХ-ны тусгай зөвшөөрөл, БОУАӨЯ-аас химийн бодис ашиглах тусгай зөвшөөрөл болон бусад зөвшөөрлийг авсны дараа гэрээлэгчийн зааварчилгааны дагуу УЦБ-ийг ашиглах эхэлнэ.

Хэрвээ УЦБ-ийн ашиглалтыг өөрсдөө хариуцах бол байгууламж хариуцсан ажилтнууд хангалттай сайн дадлагажсан эсэхийг ашиглаж эхлэхдээ магадлаарай. Үүнд УЦБ-ийн хэвийн ажиллагааг хангахаас гадна үүссэн янз бүрийн нөхцөл байдалд ямар арга хэмжээ авах, хэрхэн тохируулах, доголдлын шалтгааныг олж илрүүлэх, мөн гэнэтийн ослын үед ямар хариу арга хэмжээ авахаа мэддэг байх зэрэг орно.

ХОЛБОО БАРИХ МЭДЭЭЛЭЛ

УЦБ суурилуулах гэж буй ҮААН-дэд санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлэх тогтолцооны талаар мэдээллийг дор дурдав.

Урьдчилан цэвэрлэх байгууламж суурилуулахыг дэмжих тогтолцоо

Ангилал	Агуулга	Холбоо барих
Урьдчилан цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмжийг гаалийн татвараас хөнгөлөх, чөлөөлөх	2023 оны Засгийн газрын 107-р тогтоолоор урьдчилан цэвэрлэх байгууламжийн зарим тоног төхөөрөмжийг гаалийн татвараас чөлөөлсөн.	ХХААХҮЯ
Ногоон зээл, Японы 2 үе шаттай зээл	Урьдчилан цэвэрлэх байгууламж суурилуулахдаа хөнгөлөлттэй хүүтэй, эргэн төлөгдөх хугацаа нь урт санхүүгийн зээл авах боломжтой.	Монголын тогтвортой санхүүжилтийн холбоо, Арилжааны банкууд, Монгол-Японы төв
Ногоон гэрчилгээ	2017 оны Засгийн газрын 290-р тогтоолоор Ногоон гэрчилгээг байгаль орчинд ээлтэй дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгох журмыг баталсан.	БОУАӨЯ

Хууль тогтоомж, дүрэм журам болон техникийн дэмжлэг туслалцаатай холбоотой илүү дэлгэрэнгүй мэдээллийг холбогдох эрх бүхий байгууллагаас авна уу.